



ГОВЬСҮМБЭР АЙМАГ  
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 07 сарын 03 өдөр

Дугаар А/91

Шивээговь сум

Сумын баяр наадмын зардалд  
хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.2, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.10, Шивээговь сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн хуралдааны 06 дугаар “Сумын 2024 оны төсөв батлах тухай” тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Сумын 2024 оны “Орон нутгийн хөгжлийн сан”-ийн хөрөнгөөр хийгдэх “Баяр наадам”-ын шууд худалдан авалтыг хийх комиссыг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Комиссын дарга:

Д.Отгонжаргал

(Засаг даргын Тамгын газрын дарга)

Гишүүд:

Б.Түвшинжаргал

(Төсөв, төрийн сангийн мэргэжилтэн)

Л.Цэнд-Аюуш

(Сан хариуцсан нягтлан бодогч)

Б.Баярцэцэг

(Нярав)

Нарийн бичгийн дарга:

Д.Баттуул

(Хөрөнгө оруулалт, эдийн засаг төлөвлөлт, худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн)

2.Сумын баяр наадамд зарцуулагдах 20,000,000 (хорин сая) төгрөгийн төсвийн задаргааг хавсралтаар баталсугай.

42124 235

3.Баяр наадамд зарцуулагдах 20,000,000 (хорин сая) төгрөгийг Орон нутгийн хөгжлийн сангаас зохих журмын дагуу анхан шатны баримт бичгийн бүрдлийг ханган зарцуулахыг нягтлан бодогч (Л.Цэнд-Аюуш)-д зөвшөөрсүгэй.

4.Үндэсний их баяр наадамд зарцуулагдах төсөвт хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Отгонжаргал)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ч.СУГАРМАА



Сумын Засаг даргын 2024 оны  
07-р сарын 03-ны өдрийн 11/99  
дугаар захирамжийн хавсралт

**СУМЫН БАЯР НААДАМД ЗАРЦУУЛАГДАХ ЗАРДЛЫН ТӨСӨВ**

<b>Д/Д</b>	<b>Материалын нэр</b>	<b>Тоо ширхэг</b>	<b>Хэмжих нэгж</b>	<b>Нэг бүрийн үнэ</b>	<b>Нийт үнэ</b>
1	Айраг	700	л	10,000	7,000,000
2	Медаль	85	ш	20,000	1,700,000
3	Өргөмжлөл	64	ш	20,000	1,280,000
4	Түлхүүрийн оосор	100	ш	5,000	500,000
5	Соронзтой наалт	150	ш	6,000	900,000
6	Наадмын талбайн урсгал засварын материал	40	ш	87,500	3,500,000
7	Хэвийн боов	145	ш	4,500	652,500
8	Суурь еэвэн /том, жижиг/	6	ш	20,000	120,000
9	Ааруул /хэвтэй/	4	кг	40,000	160,000
10	Ааруул /хорхой/	12	кг	38,000	456,000
11	Цагаан идээ	3	кг	25,000	75,000
12	Бөхийн боорцог	25	кг	9,000	225,000
13	Сүү	6	л	6,000	36,000
14	Ус, ундаа	600	ш	2,200	1,320,000
15	Чихэр	15	кг	36,000	540,000
16	Жимс	30	кг	10,000	300,000
17	Хиам, өргөст хэмх	23	кг	20,000	460,000
18	Мах	40	кг	14,000	560,000
19	Бусад зардал	10	ш	21,550	215,500
	<b>НИЙТ</b>				<b>20,000,000</b>